



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА СЭРГЭЭН ЗАСАХ
АМРАЛТЫН ДАРГА Ж.АМАРСҮРЭН
ТАНАА

2022.03.15 № 07/571
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах амралтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр байсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах амралтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

Аудитад 655.9 сая төгрөгийн касс, харилцахын баримт, 346.5 сая төгрөгийн бараа материалын тайлан, 2,388.6 сая төгрөгийн хөрөнгийн тооцоо бодсон акт, худалдан авах ажиллагааны 544.0 сая төгрөгийн баримтуудыг ирүүлээгүй, санхүүгийн тайлан, тодруулга иж бүрэн бус, ерөнхий журнал, гүйлгээ балансын дүнгүүд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээс зөрүүтэй, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэргийн улмаас санхүүгийн тайлангууд бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн байсан.

Дээр дурдсан шалтгааны үр дүнд аудитын горим, сорил хэрэгжүүлж, санхүүгийн тайлангууд болон тодруулгууд нь үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулсан гэх аудитын хангалттай зохистой нотолгоо олж авч чадаагүй, үүссэн тодорхой бус байдлуудын үр дагавар ба санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөг тогтоох боломжгүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ